



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ А.ЗОЛБАЯР ТАНАА**

2020.08.31 № 256
танай _____-ны № _____-т

«Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт»

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Алтанбулаг овогтой Золбаярын /МЮ82030312/ сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Алтанбулаг овогтой Золбаярын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Алтанбулагийн Золбаярын /МЮ82030312/ мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд
Хавсралт 3. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

008020411

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ А.ЗОЛБАЯР МӨРИЙН ХӨТӨЛБӨР



2020.07.24

A handwritten signature in black ink, located at the bottom left of the page.

A handwritten signature in black ink, located at the bottom center of the page.

000000000!

A handwritten signature in black ink, located at the bottom right of the page, below the numerical code.

**БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ АЛТАНБУЛАГ ОВОГТОЙ
ЗОЛБАЯРЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Говьсүмбэр аймгийн сонгогчид оо

2020.07.24

Говьсүмбэр аймгийн унаган хүү би аймаг орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зовж өөрийн хүч хөдөлмөр, оюун ухаанаа дайчлан ажиллаж ирсэн билээ. Би аймаг орон нутагтаа хувиараа бизнес эрхлэн ажиллаж амьдардаг. Миний дээд үеийнхэн аймгийн боловсролын салбарт багш мэргэжлээр ажиллаж ирсэн удамтай. Анхны сургуулийг 3 гэртэйгээр үүсгэн байгуулсан С.Дүгэржав багшаас эхлээд түүний хойч үед 4 үеийн багш мэргэжлээр орон нутагт ажиллаж амьдарч байна. Би 4 дахь үеийн багш дасгалжуулагч мэргэжилтэй хүний хувьд аймгийн боловсролын салбарын сургалтын түвшинг улсад дээгүүр байр эзлүүлэх зорилготой явдаг хүн юм.

Гэтэл засгийн эрхийг гартаа авсан эрх баригчид дэндүү намчирхаж төрд ажиллаж байгаа туршлагатай, үнэнч шударга, хариуцлагатай албан хаагчдыг нөгөө намын хүн гэдэг өнцгөөс харж төрд хоёргүй сэтгэлтээр ажиллаж байсан албан хаагчдыг ажлаас халж, нам дагасан боловсрол мэдлэггүй, туршлагагүй, архичин, хариуцлагагүй хүнээр төрийн албыг худалдаалах явдал сүүлийн жилүүдэд манай аймагт ихээр гарч хүн бүхний нүдэнд ил болсон. Манай аймаг хамгийн залуу, хамгийн цөөн хүн амтай аймагт ингэж намчирхаж талцах, хагалан бутаргаж айл гэр бүлд хүртэл нөлөөлж аймаг орон нутгийн хөгжил цэцэглэлтэнд сөргөөр нөлөөлж байна.

Би үүнийг зүгээр хараад сууж болохгүй.

Би ганцаараа гараад бүгдийг шийдвэрлэж чадахгүйгээ мэдэж байна гэхдээ нам дагасан хүн болгон боловсрол мэдлэггүй, тэнэг мангар гэсэн үг биш тэдэн дотор улс эх орноо аймаг орон нутгаас гэсэн сэтгэлтэй, итгэлтэй хүмүүс олон бий тэдэнтэй нэгдэж болохгүй бүтэхгүй зүйлийг нь шүүмжилж, болж бүтэж байгаа зүйлийг нь сайшааж энэ орон нутгийг өнгөтэй өөдтэй сайн сайхан байлгахын төлөө үнэний дуу хоолой, үнэн шударгын талд зогсож чадна гэдгээ илэрхийлж байна.

Тиймээс сонгогч Та:

- Эрх мэдэл, хөрөнгөтэй хэн нэгний захиалгаар нэр дэвшээгүй
- Өөрийн гэсэн үзэл бодол байр суурьтай
- Үнэнч шударга, үнэт зүйлтэй
- Зөвд зөөлөн бурууд хатуу / Буруу зүйлийн төлөө бурхантай ч нэгдэхгүй, Зөв зүйлийн төлөө чөтгөртэй ч нэгдэнэ/



0000000002



21714445
70055 901

Тийм л хүн танд үйлчилж, таны төлөө, орон нутгийнхаа төлөө бодлого гаргаж хэрэгжүүлэх болно. Ийм хүмүүс бүрдсэн төрийг Та миний төр гэж төрдөө итгэлтэй байх болно.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлийг зорилт болгон дэвшүүлж байна.

- Холбоо шар барилгын ойр орчимын тохижилтыг сайжруулах
Тус барилгын хойно байрлах саадыг гэрэлт хөшөө, усан оргилуур, ногоон байгууламж, гэрэлтүүлэг бүхий тохижилтыг хийнэ.

- Усан парк байгуулна
Цэргийн алдар хөшөөний баруун урд 4 га талбайд байгуулах

- Цоорхойн рашаанд нарсан төгөл байгуулах
8 га газарт хувь хүмүүсээр /тэмдэглэлт өдрүүдээр/ мод тариулж, жил болгон арчлалтын зардлыг орон нутгийн төсвөөр шийдвэрлэх

- Чойр уул орчимд тэмээн жингийн хөшөө хийх
Торгоны замын түүхэн дурсгал, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтарч байгуулна.

- Чойр уул орчимд "Гарьд магнай" бөхийн хөшөө байгуулна.
Өөрийн хөрөнгөөр хийнэ.

- Оюун ухааны академийн салбарыг аймагт байгуулна.
Өөрийн хөрөнгөөр хийнэ. Хаан банкны урд байрлах барилгыг засварлаж сургалтын төв байгуулахаар тохиролцсон.

- Хямд өртөг бүхий орон сууцаар иргэдийг хангах
Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар, төрийн зохион байгуулалт хийх.

- Хүүхдийн ордон байгуулах
Стандарт шаардлага хангасан хүүхдийн ордон улсын төсвийн хөрөнгөөр барих

Энэхүү хөтөлбөр нь нам гэж талцахгүй нутаг гэж нэгдэх зорилготой залуучууд нэгдэн нутаг орноо хөгжүүлэхийн төлөө юм.

БОЛОВСРУУЛСАН:



А.ЗОЛБАЯР



0000000003

